



КРЕДИТ  
ББСБ

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 1 сарын 2-ны өдөр

Дугаар 2020/08

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх  
хязгаар тогтоох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 1 сарын 2-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2020 оны 1 сарын 2-ны өдрөөс 2020 оныг дуусах хүртэл хугацаанд Ард Кредит ББСБ ХК болон Ард Санхүүгийн Нэгдэл, түүний охин компаниуд, холбоотой этгээдүүдийн хооронд 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийн үнийн дүнд багтаан сонирхлын зөрчлийн хэлцэл байгуулах дээд хязгаар тогтоосугай.
2. Тогтоосон хязгаарын хүрээнд гэрээ, хэлцэл хийсэн талаар мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд мэдэгдэн, холбоотой этгээдүүдтэй хэлцэл хийх эрхийг Гүйцэтгэх захиралд Г.Тэлмэнд олгосугай.
3. Уг шийдвэрийг гаргахад Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалт явуулан хэлцэл байгуулах зөвшөөрөл олгосон, хэлцлийг батлах санал хураалтад сонирхлын зөрчилтэй этгээдүүд оролцолгүй түдгэлзсэн болохыг дурьдсугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Тэлмэнд даалгасугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

0000 040